

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



"ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН" АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ НЬ ТӨСВИЙН БОДИТ ДААЦ БОЛОН ОРОН НУТГИЙН СУУРЬ ДЭД БҮТЭЦ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ УЯЛДАА ХОЛБООГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛТЭЙ ТООЦОЛГУЙ, БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАГДААГҮЙ БАЙХАД ЗЭЭЛИЙГ ХАВТГАЙРУУЛАН ОЛГОСНООС ШАЛТГААЛАН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт,
үр дүнд хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2026/21-9/ШТА-ГА

Чойбалсан хот
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нармандах
Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор С.Төмөрхуяг
Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurkhuyags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4

БҮЛЭГ 1. "ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН" АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ НЬ ТӨСВИЙН БОДИТ ДААЦ БОЛОН ОРОН НУТГИЙН СУУРЬ ДЭД БҮТЭЦ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ УЯЛДАА ХОЛБООГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛТЭЙ ТООЦОЛГҮЙ, БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАГДААГҮЙ БАЙХАД ЗЭЭЛИЙГ МАСС ХЭЛБЭРЭЭР ОЛГОСНООС ШАЛТГААЛАН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.....	5
---	----------

1.1. "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" тогтоолын шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг бодитой төлөвлөөгүйгээс 2026 оноос эх үүсвэр тасарч зээл олголт зогссон, мөн орон нутгийн суурь дэд бүтэц, газрын харилцааны уялдааг хангаагүй, бэлтгэлгүй зээл олгосноос шалтгаалан төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байна.....	5-8
--	-----

БҮЛЭГ 2. ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ АВСАН МАЛЧИД ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАСАН БОЛОВЧ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НАРИЙН ЗААГААГҮЙГЭЭС ШАЛТГААЛАН "ХОРШОО ХЭЛБЭРЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ" ҮНДСЭН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ БАЙНА.....	8
---	----------

2.1. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан хоршоод нь хуулийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан боловч хуулиар хүлээсэн үүрэг хамтын, эрсдэлийн сангуудыг бүрдүүлж, бодитой үйл ажиллагаа явуулах шаардлагыг хангаагүй байна.....	8-10
---	------

2.2 Арилжааны банкнаас хөнгөлөлттэй зээлийг шалгуур хангасан 560 малчинд зээл олгосны 75.7 хувьд Дорнод аймаг дахь Монголбанкны салбараас зээлийн үр дүнд хяналт хэрэгжүүлсэн байна.....	10-13
--	-------

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	14-17
ДҮГНЭЛТ:	18-19
ҮАГ-ИЙН НЭГДСЭН ТАЙЛАНД САНАЛ:	19
ЗӨВЛӨМЖ:	20
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	21

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГ	Засгийн газар
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ШТА	Шууд тайлагнах аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
MNS	Mongolian national standard

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны "Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/179 дүгээр тушаалыг үндэслэн хийлээ.

Аудитын зорилт

Засгийн газрын 2024 оны 166 дугаар "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоолын хүрээнд малчинд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрөөс Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Хоршоог хуульд заасан шаардлагын дагуу байгуулж, олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнг тооцож байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад ЗГ-ын 2024 оны 166 дугаар "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоолоор "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэгч Монгол банк, ХХААГ, Улсын бүртгэлийн хэлтэс, Хаан банк, Төрийн банк, Хас банк, Зээлийн батлан даалтын сан, Аймгийн Засаг дарга болон Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд зээл авсан 176 хоршооны 560 малчдыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер Д.Нармандах аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, С.Төмөрхуяг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын дэд төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 6 дугаар сарын 22-ны өдрөөс 6 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг ҮАГ болон холбогдох байгууллагад хүргүүллээ.

БҮЛЭГ 1. "ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН" АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ НЬ ТӨСВИЙН БОДИТ ДААЦ БОЛОН ОРОН НУТГИЙН СУУРЬ ДЭД БҮТЭЦ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ УЯЛДАА ХОЛБООГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛТЭЙ ТООЦОЛГҮЙ, БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАГДААГҮЙ БАЙХАД ЗЭЭЛИЙГ ХАВТГАЙРУУЛАН ОЛГОСНООС ШАЛТГААЛАН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

1.1. "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" тогтоолын шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг бодитой төлөвлөөгүйгээс 2026 оноос эх үүсвэр тасарч зээл олголт зогссон, мөн орон нутгийн суурь дэд бүтэц, газрын харилцааны уялдааг хангаагүй, бэлтгэлгүй зээл олгосноос шалтгаалан төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байна.

1.1.2 "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөнд хүрэх түвшин болон шаардагдах хөрөнгийг бодитой тооцоогүй байна.

Засгийн газрын "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" 2024 оны 166 дугаар тогтоолын хавсралтаар "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хэрэгжүүлэх 5 (тав) их наядын "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.

Төлөвлөгөөг боловсруулахдаа төсвийн бодит даац, салбар хоорондын уялдаа болон малчдын бизнесийн чадавхыг эдийн засгийн үндэслэлтэй тооцолгүйгээр, зөвхөн "тоон" үзүүлэлт давамгайлсан байна. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн нөөц, судалгаанд үндэслэсэн байх зарчмыг хангаагүй байна.

Аудитаар илэрсэн асуудал.

1. Төсөв, санхүүгийн төлөвлөлт бодит боломжтой уялдаагүй байдал. Засгийн газраас тус арга хэмжээнд зориулж нийт 5 их наяд төгрөг зарцуулахаар төлөвлөж, хоршооны гишүүн малчдад 2029 он хүртэл зээл олгохоор тусгасан. Гэвч Дорнод аймгийн хэмжээнд 2024-2025 онд 176 хоршооны 560 малчинд 22.2 тэрбум төгрөгийн зээл олгоод, 2026 оноос санхүүжилтийн эх үүсвэргүй болж зээл олголт зогссон байна. Энэ нь төсвийн бодит даацыг дутуу тооцсоныг илтгэж байна.

2. Бодлогын уялдаа холбоо, орон нутгийн оролцоо хангагдаагүй байдал. Төлөвлөгөөг боловсруулахдаа аймаг, сумдаас судалгаа авч дүгнээгүй, орон нутагт төсөв хуваарилаагүй байна. Түүнчлэн тус арга хэмжээний хүрээнд тусгасан ажлуудыг орон нутгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулаагүйгээс шалтгаалан, хэрэгжилтийг хянах боломжийг бүрдүүлээгүй байна.

3. Суурь дэд бүтэц, газар зохион байгуулалтын дутагдал. Малчид зээл аваад хоршооны зориулалтаар түүхий эд бэлтгэх цех, агуулах, тэжээлийн талбай байгуулах гэсэн боловч сумдад газар олголтын асуудал нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаж шийдвэрлэгдээгүй байснаас шалтгаалан

хүлээлтийн /удаашралын/ байдалд байна. Энэ нь санхүүжилт олгосон ч ажил хэрэгжих боломжгүй эрсдэлийг үүсгэжээ.

4. Хүрэх түвшин, чанарын үр нөлөөний дутуу тооцоолол

- **Тоон үзүүлэлт:** Дорнод аймагт "Шинэ хоршоо" хөдөлгөөн өрнөхийн өмнө 164 хоршоо байсан бол хөдөлгөөний хүрээнд 202 хоршоо шинээр нэмэгдэж, 366 хоршоотой болж тооны хувьд өссөн.
- **Чанарын үзүүлэлт:** Хоршоолж хөдөлмөрлөх бодит агуулгаас илүүтэйгээр жилийн 6%-ийн хүүтэй, 50 сая төгрөгийн зээл авахын тулд төрөл садан, танилуудаараа нэгдэж хоршоо байгуулсан нь урт хугацааны нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл хөгжихөд чиглэгдээгүй байна.
- **Зах зээлийн уялдаа:** Малчид түүхий эдээ бэлтгэдэг цехтэй боллоо ч түүнийг нь худалдаж авах дотоод, гадаадын үйлдвэрлэл, экспортын гарц, логистикийн сүлжээг бүрэн бүрдүүлээгүй байж анхан шатны зээлийг хавтгайруулан олгосон байна.

“Шинэ хоршоо–Чинээлэг малчин” арга хэмжээний хүрээнд байгуулагдсан хоршоодын үйл ажиллагааны тогтвортой байдал, үйлдвэрлэгчидтэй түүхий эд нийлүүлэх гэрээгээр бодитой холбох, зах зээлийн хэрэгцээг үнэлж, орон нутгийн онцлогт нийцсэн дэмжлэгийн арга хэмжээг зохион байгуулах **зөвлөмжийг Дорнод аймгийн Засаг даргад өгөв.**

ҮАГ-т уламжилж нэгтгэсэн тайланд: Дараагийн шатны "Шинэ хоршоо 2" хөдөлгөөнийг эхлүүлэхдээ улсын төсвөөс санхүүжүүлэхийг зогсоож, зөвхөн олон улсын байгууллагууд (АХБ, НҮБ) болон Ногоон зээлийн эх үүсвэрт тулгуурласан нарийн шалгууртай санхүүжилтийн загварт шилжих тухай аудитын бодлогын шийдвэрийг ЗГ-т хүргүүлэх.

1.1.3 “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий байгууллагууд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны 2024, 2025 оны 01 дүгээр тогтоолоор “үйл ажиллагааны төлөвлөгөө” баталсан байна.

“Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий байгууллагууд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хавтгайруулан зээл олголт, уулзалт сургалтыг зэрэгцүүлэн зохион байгуулсан боловч төлөвлөгөөний гол цөм болсон малчдын хоршооны үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах, үйлдвэрлэл эрхлэх суурь нөхцөл буюу “малчдад газар эзэмшүүлэх” Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг аймаг, сумын Засаг дарга нарын түвшинд хангаж чадаагүй байна. Үндэсний хорооноос баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, хяналт-шинжилгээ сул байна.

Аудитаар илэрсэн асуудал.

Бодлогын уялдаа холбоо хангагдаагүй байдал. Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын 7 дахь заалтаар малчдын хоршоог хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах чиглэлийг өгсөн. Түүнчлэн Үндэсний хорооны 2024 оны төлөвлөгөөнд аймаг, сумын ЗДТГ-т хамаарах 7 арга хэмжээ тусгагдсан боловч орон нутгийн түвшинд хийсэн ажил байхгүй, төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайлагнаагүй байна.

Малчдын хоршоонд газар олгох үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байдал. Төлөвлөгөөнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд газар олгох асуудлыг аймаг, сумын ЗДТГ хамтран хэрэгжүүлэхээр заасан. Бодит байдалд:

- Дорнод аймгийн 14 сумдаас зөвхөн 4 сум (Дашбалбар, Чойбалсан, Хэрлэн, Цагаан-Овоо) 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тарих чиглэлээр төсөл сонгон шалгаруулалт зарласнаас Чойбалсан (3), Цагаан-Овоо (2) сумдад нийт 5 төсөл шалгарч гэрээ байгуулсан.
- 2025 онд Дашбалбар, Цагаан-Овоо сумдад зарласан шалгаруулалт оролцогчгүй гэх шалтгаанаар цуцлагдсан.
- Аймгийн хэмжээнд зээл авсан 176 хоршооноос ердөө **5 хоршоонд газар олгосон** нь газар зохион байгуулалтын дэмжлэг хангалтгүй байсныг нотолно.

Төлөвлөгөөний хугацаа хоцорсон ба хэрэгжилтийн хувь хэмжээ. Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2024 оны 11 сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор тус хорооны 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Аймаг, сумдын ЗДТГ-т хамаарах 7 арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй байна. Аудитаар "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний 2024 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхэд хэрэгжилт 28.4 хувьтай байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2025 оны 01 сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор тус хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Аймаг, сумдын ЗДТГ-т хамаарах 28 арга хэмжээний 1 дүгээр улирлын биелэлтийг гарган 64.6 хувиар дүгнэж, Дорнод аймгийн Засаг даргын орлогчийн 2025.04.15-ны өдрийн 1/903 тоот албан бичгээр Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хороонд хүргүүлсэн байна. Бусад улирлын төлөвлөгөөний хэрэгжилтийг Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хороонд албан бичгээр хүргүүлээгүй байна. Аудитаар "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний 2025 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхэд хэрэгжилт 21.4 хувьтай байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны 2024, 2025 оны 01 дүгээр тогтоолоор "үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилт орон нутагт хангалтгүй байгаа нь дараах хүчин зүйлээс шалтгаалсан байна. Үүнд:

1. Шинэ хоршоо хөдөлгөөнийг хэрэгжүүлэхдээ орон нутагт бэлтгэл ажлыг бүрэн хангаагүй байхад малчдад зээл олгосон. /мэдээлэл сургалт, бэлтгэл хангах ажил, зээл олголт зэрэг хийгдсэн/
2. Орон нутагт үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх цаг хугацаа хомс байсан. /Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2024 оны 11 сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор тус хорооны 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан/

Дорнод аймгийн Засаг даргад дараах зөвлөмжийг өгөв.

1. Хоршоолсон малчдад үйлдвэрлэл, агуулах, тэжээлийн талбайн зориулалтаар газар олгох төсөл сонгон шалгаруулалтыг эрчимжүүлэх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах үүргийг сумдын Засаг дарга нарт өгч, хэрэгжилтэд хяналт тавих.
2. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд зээл авсан хоршоодын үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт болон дунд, урт хугацааны хөтөлбөрүүдтэй уялдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

БҮЛЭГ 2. ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ АВСАН МАЛЧИД ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАСАН БОЛОВЧ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НАРИЙН ЗААГААГҮЙГЭЭС ШАЛТГААЛАН "ХОРШОО ХЭЛБЭРЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ" ҮНДСЭН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ БАЙНА.

2.1. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан хоршоод нь хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан боловч хуулиар хүлээсэн үүрэг, хамтын, эрсдэлийн сангуудыг бүрдүүлж, бодитой үйл ажиллагаа явуулах шаардлагыг хангаагүй байна.

2.1.1 Хоршоог үүсгэн байгуулсан гэрээнд хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан 176 хоршоод нь хоршоог үүсгэн байгуулсан гэрээнд хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан байна.

2.1.2 Хоршооны дүрэмд хоршоог үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна.

Хоршооны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т "Хоршоог үүсгэн байгуулах бичиг нь хоршооны дүрэм байна." 10.3.7-д "Хоршооны гишүүний заавал оруулах хувь хөрөнгийн хэмжээ, хугацаа" гэсэн заалтын дагуу хоршоог үүсгэн байгуулахдаа дүрэм болон хөрөнгийн хэмжээг тусгасан байх шаардлагатай. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон малчны зээлд хамрагдсан 176 хоршооны дүрэмд гишүүний оруулах хувь, хөрөнгийн хэмжээг тусгаж хоршооны гишүүдийн хурлаар баталж улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж гэрчилгээ авч ажилласан байна.

2.1.3 Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасныг үндэслэн хоршооны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийг байршуулаагүй байна.

Хоршооны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Хоршооны хөгжил, хоршооны гишүүний нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, амьдралын чанар, амьдрах орчныг сайжруулах зорилгоор хоршоо хөгжлийн сантай байж болно." , 10 дугаар зүйлийн 10.3.21-т "хоршооны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хувь хэмжээ;" гэж заасан байдаг. Дорнод аймгийн хэмжээнд Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон малчны зээлд хамрагдсан 176 хоршоо нь хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлж ажиллаагүй байна.

Хоршоод цаасан дээр дүрэм, гэрээг баталсан ч бодит байдал дээр зээлийн хөрөнгө хоршооны дансаар дамжин эргэлтэд орохгүй, хамтын үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас шалтгаалан Хоршооны тухай хуулиар хүлээсэн хөгжлийн санг байгуулаагүй, санхүүгийн чадамжгүй хэлбэртэй байна.

ҮАГ-т нэгтгэсэн тайланд: "Засгийн газарт дараагийн шатны зээл, санхүүжилтийг тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, санхүүгийн сангаа бүрдүүлсэн хоршоодод нарийн шалгуураар олгодог бодлогын шилжилт хийх" аудитын шийдвэрийг тусгуулах саналыг хүргүүлэх.

2.1.4 Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасныг үндэслэн болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийг байршуулаагүй байна.

Хоршооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т "Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна" гэж заасан байна. Дорнод аймгийн хэмжээнд Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон малчны зээлд хамрагдсан 176 хоршоо нь болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хөрөнгө байршуулж ажиллаагүй байна.

Хоршоод цаасан дээр дүрэм, гэрээг баталсан ч бодит байдал дээр зээлийн хөрөнгө хоршооны дансаар дамжин эргэлтэд орохгүй, хамтын үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас шалтгаалан Хоршооны тухай хуулиар хүлээсэн болзошгүй эрсдэлээс хамгаалах санг байгуулаагүй, санхүүгийн чадамжгүй хэлбэртэй байна.

2.1.5 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 35 хувь нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу санхүүгийн тайлангаа гаргаагүй, мөн хөдөлгөөний хүрээнд бий болсон тээврийн хэрэгсэл, трактор, тоног төхөөрөмжийг хоршооны санхүүгийн тайланд тусгаагүй, тракторт улсын дугаар, гэрчилгээ аваагүй, татвар хураамж төлөөгүй.

Хоршооны тухай хуулийн 23.1 дүгээр зүйлд хоршооны хөрөнгө, эх үүсвэрийг хуульд заасан журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бүртгэх үүрэгтэй гэж заасан. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд малчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээлийн ашиглалт, бүртгэлд шалгалт хийхэд дараах зөрчил илэрсэн.

- Санхүүгийн тайлагнал хангалтгүй: Зээлд хамрагдсан нийт 176 хоршооны 35 хувь буюу 62 хоршоо нь Төрийн сангийн цахим систем болон татварын цахим системд холбогдох санхүүгийн тайлангаа гаргаж ажиллаагүй байна.
- Хөрөнгийн бүртгэл дутуу: Тус хөдөлгөөний хүрээнд олгогдсон нийт 22.2 тэрбум төгрөгийн зээлийн хөрөнгө оруулалтыг хоршооны дансаар дамжуулаагүй. Хөдөлгөөний хүрээнд бий болсон 4,408.0 сая төгрөгийн 147 ширхэг трактор, тээврийн хэрэгслийг хоршооны санхүүгийн тайланд тусгаагүй, тракторт улсын дугаар, гэрчилгээ аваагүй, татвар хураамж төлөөгүй.

Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний 1.1-т "хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох" гэж заасны дагуу *зээлийг хоршооны дундын дансаар биш, гишүүн малчны хувийн дансаар дамжуулан олгосон нь хоршоо хөрөнгөө нэгдсэн бүртгэлд авч чадахгүйд хүрэх үндсэн шалтгаан болжээ.*

Үр дагавар, эрсдэл. Хоршоодын санхүүгийн үйл ажиллагаа хаалттай болж, ил тод байдал алдагдах, зээлийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалтад тавих хяналт сулрах, улмаар зээлийн эргэн төлөлт тасалдах эрсдэлтэй байна.

Аймгийн Засаг даргад дараах зөвлөмжийг өгөх.

1. Зээлд хамрагдсан хоршоодыг Төрийн сан болон татварын цахим системд бүрэн холбож, санхүүгийн тайланг хуулийн дагуу гаргаж хэвшүүлэхийг ЗДТГ-ын холбогдох хэлтэст үүрэг болгож, хэрэгжилтэд хяналт тавих.
2. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн хоршооны үндсэн хөрөнгөд нэгдсэн байдлаар бүртгэлд авах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.2 Арилжааны банкнаас хөнгөлөлттэй зээлийг шалгуур хангасан 560 малчинд олгосны 75.7 хувьд Дорнод аймаг дахь Монголбанкны салбараас зээлд хяналт хэрэгжүүлсэн байна.

2.2.1 Шалгуур хангасан хоршооны гишүүнд "Хоршооны гишүүн малчны зээл"-ийг олгосон байна.

Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөтөлбөрийн хүрээнд "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний гуравдугаар зүйлд заасан "Зээл хүсэгчид тавих шаардлага"-ыг хангасан 176 хоршооны 560 гишүүдэд зээлийг олгосон байна.

Хүснэгт №1

№	Зээлийн зориулалт	Гишүүдийн тоо	Зээлийн дүн	
1	Бэлчээрт худаг уст цэг гаргах усан хангамж байгуулах	Усан хангамж байгуулах	3	125.0
		Бэлчээрт худаг	15	560.0
		Уст цэг гаргах	3	115.0
2	Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах тэжээлийн үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	11	490.0

3	Мал бордох аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	Мал бордох аж ахуй байгуулах	6	178.0
		Мал бордох аж ахуй өргөтгөх	3	119.5
		Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	19	772.5
4	Мах сүү цагаан идээ бэлтгэх боловсруулах үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	14	520.0
		Мах, сүү, цагаан идээ бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл, цех байгуулах, өргөтгөх	7	255.0
5	Үржлийн мал худалдан бойжуулах борлуулах		176	7,027.0
6	Ноос ноолуур арьс шир бэлтгэх анхан шатны тордолт хийх цэг цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх		1	20.0
7	Дотор мах боловсруулах үйлдвэр цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх		1	45.0
8	Мал малын гаралтай түүхий эдийн агуулах зоорь хөргүүр байгуулах		4	128.6
9	Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлэх		128	5,052.2
10	Гахай шувуу зөгий цаа буга зэрэг ашиг шимийг нь тогтмол хүртдэг тэжээвэр амьтны аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх		1	40.0
11	ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих өргөтгөх засварлах тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл автомашин тоног төхөөрөмж худалдан авах		44	1,609.4
12	Бусад		124	5,220.5
НИЙТ			560	22,277.7

Хүснэгтээс харахад үржлийн мал худалдан авч бойжуулах, борлуулах зориулалтаар 176 малчин нийт 7 тэрбум төгрөг авсан нь дийлэнх хувь буюу 31.8 хувийг эзэлж байна.

График №1



График №2



Дээрх графикаас харахад нийт зээлийн 63 хувийг Төрийн банк, 35.6 хувийг ХААН банк, 1.4 хувийг ХасБанк олгожээ.

2.2.2 Дорнод аймгийн хэмжээнд "Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөдөлгөөн"-д олгосон зээлийн эргэн төлөлт зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу төлөгдөж байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Дорнод аймагт нийт 176 хоршооны 560 гишүүнд 22,277.6 сая төгрөгийн зээл олгосон байна. 2026 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар 176 хоршооны 556 гишүүний 20,287.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд хугацаа хэтэрсэн зээлдэгч байхгүй байна.

Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 2.1.14-т "Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: Зээлдэгчийн орлоготой уялдуулан банк зээлдэгчтэй хамтран тогтоох бөгөөд 12 сараас хэтрэхгүй" гэсний дагуу 128 зээлдэгчийн 5,132.0 сая төгрөгийн зээлийн үндсэн төлөлт эхлээгүй байна.

Аудит хамрах хугацаанд 4 хоршооны 4 зээлдэгч 170.0 сая төгрөгийн зээлийг графикт хугацаанаас өмнө урьдчилан төлж барагдуулсан байна.

2.2.3 Дорнод аймаг дахь Монголбанкны салбараас Төрийн банк болон ХААН банканд нийт 5 удаа хяналт хэрэгжүүлж илэрсэн зөрчлүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтийг улирал бүр тооцон ажилласан байна.

ХААН банк болон Төрийн банкны сумдын тооцооны төвүүд нь зээлийн зарцуулалтын газар дээрх хяналтыг хэрэгжүүлсэн байна.

ХААН банк болон Төрийн банкны Дорнод аймаг дахь салбаруудаас харьяа тооцооны төвүүдийн олгосон зээлүүдэд хяналт хэрэгжүүлсэн байна.

Дорнод аймаг дахь Монголбанкны салбараас арилжааны банкнуудад дараах хяналт, шалгалтуудыг хийсэн байна. Үүнд:

- Төрийн банканд 2024 онд 1 удаа 2025 онд 2 удаа иж бүрэн шалгалт хийсэн бөгөөд 358 хоршооны гишүүний зээлийг хамруулсан байна.
- ХААН банканд 2025 оны 11 сард хэсэгчилсэн, 2026 оны 2 сард иж бүрэн шалгалт хийж шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон 66 зээлийг хамруулан шалгасан байна.

Монголбанкны салбар нь арилжааны банкнаас зээл авсан 560 малчнаас 424 малчны зээл буюу 75.7 хувьд хяналт, шалгалт хийсэн байна.

Харин Монголбанкны салбараас ХасБанкнаас Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлэнд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол банкны 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд ХасБанкны хоршооны зээл тусгагдаагүй байсантай холбоотой бөгөөд 2026 оны төлөвлөгөөнд Хас банканд иж бүрэн шалгалт тусгагдсан байна.

Зээлийн батлан даалтын сан Дорнод аймгийн хэмжээнд хоршооны гишүүн 289 малчин өрхийн 11,128.6 сая төгрөгийн зээлд 7,995.5 сая төгрөгийн зээлийн батлан даалт гаргасан байна. ЗБДС-аас 2024-2025 онуудад Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Төрийн банк болон Хаан банкны олгосон батлан даалттай зээлүүдэд

хяналт хэрэгжүүлж ажилласан бол ХасБанкнаас олгосон 2 хоршооны 9 гишүүний 339.0 сая төгрөгийн зээлд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Монголбанк, Зээлийн батлан даалтын санд ХасБанкнаас олгосон 339.0 сая төгрөгийн 9 зээлдэгчид хяналт, шалгалт хэрэгжүүлэх **зөвлөмж өгөв**.

ХасБанканд Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн зарцуулалтын хяналтыг хэрэгжүүлэх **зөвлөмж өгөв**.

2.2.4 Хөнгөлөлттэй зээл авсан малчид зээлийг зориулалтын дагуу ашигласан боловч зээлийн гэрээнд хамтын үйл ажиллагааг нарийн заагаагүйгээс шалтгаалан "хоршоо хэлбэрээр хамтран ажиллах" үндсэн зорилгын хүрээнд үр дүнд хүрээгүй байна.

Хөнгөлөлттэй зээл нь хувь малчны түвшинд мал аж ахуйн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтад зориулалтын дагуу ашиглагдсан боловч зээлийн гэрээнд хамтын үйл ажиллагааг нарийн заагаагүй, сумын түвшинд газар олголт шийдэгдээгүйгээс шалтгаалан "хоршоо хэлбэрээр хамтран ажиллах, ченжийн тогтолцоог халах" үндсэн зорилгын үр дүндээ хүрээгүй байна.


Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хавсралт болох "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөрийн 1.1-т хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох гэж заасан.

Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн гэрээний 1.3.4-т "Хоршоо гэж иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт заасныг гэснээр бусдаар хоршоо хэлбэрээр хэрхэн хамтран ажиллах, тус зээлийг хоршооны дансаар дамжуулах зэрэг талаар тодорхой тусгаагүй байна.

Өөрөөр хэлбэл гэрээндээ хуулийн ерөнхий заалтуудыг хуулж оруулснаас биш, амьдрал дээр малчид хэрхэн хөдөлмөрөө хорших, зээлээ яаж дундын дансаар дамжуулж агуулах, цех барихад зарцуулах, хэрэв зээлээ төлж чадахгүй бол ямар хариуцлага хүлээхийг нарийвчлан зааж өгөөгүй. Үүнээс болоод малчид хоршооны дундын хөгжилд биш, хувь малчин өөрийн хэрэгцээндээ тус тусдаа зарцуулсан байна.

ҮАГ-т уламжилж нэгтгэсэн тайланд тусгуулах: "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөр нь хоршооны гишүүн малчин хэлбэрээр хөгжих, Иргэний хууль болон Хоршооны тухай хуульд заасны дагуу хоршоо хэлбэрээр хөгжих эсэхийг нарийн тодорхой болгох. Шинээр байгуулагдсан хоршоодын үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй, үр дүнтэй явуулах арга замыг бодлогын хэмжээнд гаргах аудитын шийдвэрийг ЗГ-т хүргүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4202, факс: 7058-4584
Цахим шуудан: azdtg@dornod.gov.mn
Цахим хуудас: Dornod.gov.mn

2026.06.25 № 01/1553


танай _____ -ны № _____ -т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжид өгөх саналгүй болно.

Аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг холбогдох хугацаанд багтаан хүргүүлэх болно.

Б. Баммурсал
Майлаар хавсаргас, тунхаглас, баталсан тушаал.

ЗАСАГ ДАРГА  Ш.ЁЛ

Ш.ЁЛ
2026.06.25
dada.

9126070327

555



**ТӨРИЙН
БАНК**

ТӨРИЙН БАНК

ДОРНОД САЛБАР

21040, Дорнод аймаг, Хэрлэн сум
7-р баг, Ольхон ХХК-ний хойд талд
Утас: 70584688 Факс: (976-11) 319044
И-мэйл: s2617@statebank.mn

Вэбсайт: www.statebank.mn, Лавлах төв: 1800-1881

2026.06.25 № 43/443
Танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

"Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

САЛБАРЫН ЗАХИРАЛ



Б.НАРАНГАРАВ

Б.Нарангарав

*Аудиторын аудитын
тайланг хавсаргах.*

Б.Т
2026.06.25
2143030870



ЗЭЭЛИЙН БАТЛАН
ДААЛТЫН САН

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН
ЗҮҮН БҮСИЙН САЛБАР**

766 байр, Маршал хотхон,
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21060
Утас: 7700 9799, Цахим шуудан: dornod_info@cgf.mn,
Цахим хуудас: www.cgf.mn

2026.06.26 № 09/36
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Аудитын тайланд санал
хүргүүлэх тухай

Шинэ хоршоо хөдөлгөөнд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд хийсэн аудитын тайланд саналгүй болно.

ЗҮҮН БҮСИЙН
САЛБАРЫН ЗАХИРАЛ



Б.МӨНХ-ОД

2126130043



20 2021 оны 06 сарын 26 өдөр № 165/278

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Шинэ хоршоо хөдөлгөөнд олгосон зээл, эргэн төлөлт,
үр дүнд хийсэн аудитын тайланд саналгүй болно.

ЗАХИРАЛ



Ц.ТУНГАЛАГТУЯА

ДОРНОД САЛБАР
Дорнод аймаг, Хэрлэн сум,
6 баг, Читын гудамж
ХасБанкны байр

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1.1. "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" тогтоолын шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг бодитой төлөвлөөгүйгээс 2026 оноос эх үүсвэр тасарч зээл олголт зогссон, мөн орон нутгийн суурь дэд бүтэц, газрын харилцааны уялдааг хангаагүй, бэлтгэлгүй зээл олгосноос шалтгаалан төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байна.

1.1.2 "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөнд хүрэх түвшин болон шаардагдах хөрөнгийг бодитой тооцоогүй байна.

1.1.3 "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий байгууллагууд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.1. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан хоршоод нь хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан боловч хуулиар хүлээсэн үүрэг, хамтын, эрсдэлийн сангуудыг бүрдүүлж, бодитой үйл ажиллагаа явуулах шаардлагыг хангаагүй байна.

2.1.1 Хоршоог үүсгэн байгуулсан гэрээнд хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан байна.

2.1.2 Хоршооны дүрэмд хоршоог үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна.

2.1.3 Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасныг үндэслэн хоршооны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийг байршуулаагүй байна.

2.1.4 Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасныг үндэслэн болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийг байршуулаагүй байна.

2.1.5 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 35 хувь нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу санхүүгийн тайлангаа гаргаагүй, мөн хөдөлгөөний хүрээнд бий болсон тээврийн хэрэгсэл, трактор, тоног төхөөрөмжийг хоршооны санхүүгийн тайланд тусгаагүй, тракторт улсын дугаар, гэрчилгээ аваагүй, татвар хураамж төлөөгүй.

2.2 Арилжааны банкнаас хөнгөлөлттэй зээлийг шалгуур хангасан 560 малчинд зээл олгосны 75.7 хувьд Дорнод аймаг дахь Монголбанкны салбараас зээлд хяналт хэрэгжүүлсэн байна.

2.2.1 Шалгуур хангасан хоршооны гишүүнд "Хоршооны гишүүн малчны зээл"-ийг олгосон байна.

2.2.2 Дорнод аймгийн хэмжээнд "Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөдөлгөөн"-д олгосон зээлийн эргэн төлөлт зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу төлөгдөж байна.

2.2.3 Дорнод аймаг дахь Монголбанкны салбараас Төрийн банк болон ХААН банканд нийт 5 удаа хяналт хэрэгжүүлж илэрсэн зөрчлүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтийг улирал бүр тооцон ажилласан байна.

2.2.4 Хөнгөлөлттэй зээл авсан малчид зээлийг зориулалтын дагуу ашигласан боловч зээлийн гэрээнд хамтын үйл ажиллагааг нарийн заагаагүйгээс шалтгаалан "хоршоо хэлбэрээр хамтран ажиллах" үндсэн зорилгын хүрээнд үр дүнд хүрээгүй байна.

Аудитаар нийт 4,747.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 8 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 3 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Дараагийн шатны "Шинэ хоршоо 2" хөдөлгөөнийг эхлүүлэхдээ улсын төсвөөс санхүүжүүлэхийг зогсоож, зөвхөн олон улсын байгууллагууд (АХБ, НҮБ) болон Ногоон зээлийн эх үүсвэрт тулгуурласан нарийн шалгууртай санхүүжилтийн загварт шилжих аудитын шийдвэрийг ЗГ-т хүргүүлэх.
2. Дараагийн шатны зээл, санхүүжилтийг тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, санхүүгийн сангаа бүрдүүлсэн хоршоодод нарийн шалгуураар олгодог бодлогын шилжилт хийх аудитын бодлогын шийдвэрийг ЗГ-т хүргүүлэх.
3. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөр нь хоршооны гишүүн малчин хэлбэрээр хөгжих, Иргэний хууль болон Хоршооны тухай хуульд заасны дагуу хоршоо хэлбэрээр хөгжих эсэхийг нарийн тодорхой болгох. Шинээр байгуулагдсан хоршоодын үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй, үр дүнтэй явуулах арга замыг бодлогын хэмжээнд гаргах аудитын шийдвэрийг ЗГ-т хүргүүлэх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Дорнод аймгийн Засаг даргад:

1. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний хүрээнд байгуулагдсан хоршоодын үйл ажиллагааны тогтвортой байдал, үйлдвэрлэгчидтэй түүхий эд нийлүүлэх гэрээгээр бодитой холбох, зах зээлийн хэрэгцээг үнэлж, орон нутгийн онцлогт нийцсэн дэмжлэгийн арга хэмжээг зохион байгуулах.
2. Хоршоолсон малчдад үйлдвэрлэл, агуулах, тэжээлийн талбайн зориулалтаар газар олгох төсөл сонгон шалгаруулалтыг эрчимжүүлэх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах үүргийг сумдын Засаг дарга нарт өгч, хэрэгжилтэд хяналт тавих.
3. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд зээл авсан хоршоодын үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт болон дунд, урт хугацааны хөтөлбөрүүдтэй уялдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

4. Зээлд хамрагдсан хоршоодыг Төрийн сан болон татварын цахим системд бүрэн холбож, санхүүгийн тайланг хуулийн дагуу гаргаж хэвшүүлэхийг ЗДТГ-ын холбогдох хэлтэст үүрэг болгож, хэрэгжилтэд хяналт тавих.

5. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн хоршооны үндсэн хөрөнгөд нэгдсэн байдлаар бүртгэлд авах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Дорнод аймаг дахь Монголбанкны салбарт:

1. ХасБанкнаас олгосон зээлд хяналт, шалгалт хэрэгжүүлэх.

Зээлийн батлан даалтын сангийн зүүн бүсийн салбарт:

1. ХасБанкнаас олгосон зээлд хяналт, шалгалт хэрэгжүүлэх.

ХасБанкны Дорнод салбарт:

1. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн зарцуулалтын хяналтыг хэрэгжүүлэх.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д *"Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ"* гэж заасан.

Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2027 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 1/21

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/175 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Дорнод аймаг дахь Монголбанкны салбар, Төрийн банкны Дорнод салбар, ХААН банкны Дорнод салбар, ХасБанкны Дорнод салбар, Зээлийн батлан даалтын сангийн зүүн бүсийн салбарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

2126010012

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр, 4 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn